

ЭНЭТХЭГ БА ҮЛ НЭГДЭХ ГАДААД БОДЛОГО

*Г.Баасанхүү**

Энэтхэг улс юугаараа алдартай билээ гэхэд буддын болон хинду шашин, эртнээс уламжлалт соёл, мэдээлэл технологийн салбарт гаргаж байгаа амжилт гээд тоочоод байвал олон зүйлийг дурдах нь мэдээж.

Мөн Энэтхэг улс нь дэлхийн 100 гаран улсыг эгнээндээ нэгтгэсэн Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг санаачлагч улсуудын нэг бөгөөд үл нэгдэх гадаад бодлогын стратегийг анхлан боловсруулсан Энэтхэгийн үндэсний чөлөөлөх хөдөлгөөний удирдагчид Махадма Ганди болон Жавхарал Неру нарын үйлстэй уг бодлогын хэрэгжилт салшгүй холбоотой.

Монголчууд бид Ж.Неругийн талаар их олныг мэддэг хэдий ч М.Гандигийн талаар тэр бүр бүрэн дүүрэн мэдээлэлгүй байдаг. Үнэндээ эвсэлд үл нэгдэх бодлогыг санаачлагч нь Ж.Неру хийгээд М.Ганди хоёул мөн юм. Махадма Ганди үл нэгдэх бодлогын анхны суурийг тавьж, хүрээг нь тодорхойлсон бол хэрхэн хэрэгжүүлэх арга замыг Ж.Неру боловсруулан төгөлдөржүүлж чадсан бөлгөө. М.Гандигийн боловсруулсан “сатьяграх” буюу хүч үл хэрэглэх хөдөлгөөний үзэл санаа¹ нь нэг зэрэг үл нэгдэх гадаад бодлогод тод тусгалаа олсон байдаг.

I. Үл нэгдэх гадаад бодлогын үүсэл

Энэтхэгийн уламжлалт шашин-сэтгэлгээний гүн ухаан төвийг сахин амарлингуй орших, үл дайсагнах, энхийг эрхэмлэх үзэл санаагаар дүүрэн байдаг. Энэтхэгийн үндэсний чөлөөлөх хөдөлгөөний удирдагч М.Ганди энэтхэгийн соёл иргэншлийн эл хөрсөн дээр тусгаар тогтнохоор тэмцэж байсан шинэ Энэтхэгийн дотоод болон гадаад бодлогыг тодорхойлжээ.

Үл нэгдэх гадаад бодлогын чиглэлийг төлөвшихөд Энэтхэгийн тусгаар тогтнолын төлөө урт хугацааны тэмцэл, дотоод улс төрийн болон олон улсын нөхцөл байдал нөлөөлж ирсэн. Үүнд, 1885 онд үүсэн байгуулагдсан Энэтхэгийн үндэсний конгресс намын үйл ажиллагаа түүхэн чухал үүрэг гүйцэтгэсэн байдгийг энэтхэгийн төдийгүй гадаадын олон судлаачид үнэлэн онцолсон байдаг.² М.Ганди тэргүүтэй Энэтхэгийн Үндэсний конгресс нам нь тусгаар тогтнолын тэмцлийн эхэн үеэс л бүх улстай найрсаг харилцан зэрэгцэн орших эрмэлзэлтэй болохоо тунхагласан гадаад бодлогын чанартай баримтуудыг гаргаж байсан нь хожим үл нэгдэх бодлогыг үндэслэхэд нөлөөлсөн чухал хөрс болсон гэж болно.³ Үүнд тус намын Бүх энэтхэгийн хорооноос 1921, 1927 онуудад гаргасан тогтоол болон бусад баримтыг онцлох нь зүйтэй болов уу.

* Г.Баасанхүү - МУИС-ийн Олон Улсын Харилцааны Сургуулийн багш

1921 онд Энэтхэгийн үндэсний конгресс намаас батлан гаргасан Энэтхэгийн гадаад бодлогын тогтоол нь угтаа М.Гандийг боловсруулсан шат ахин тайван замаар тусгаар тогтнолдоо хүрэх нэг алхам болж чадсан юм. Уг тогтоолоор Британий эзэнт гүрний бүрэлдэхүүнд байсан Энэтхэг бие даасан гадаад бодлогын чиглэлээ тунхаглаж, колоничлолийн эсрэг тууштай тэмцэхээ тунхагласан юм.

М.Ганди тусгаар тогтнолд тайван тэмцлээр, хүч хэрэглэлгүй хүрч болохыг онцолж байсан нь 1948 онд Мадан Гопалыг болон бусад энэтхэгийн түүхч, улс төрчдийг “үл нэгдэх дэлхийн энх тайвны”⁴ тогтоож болно гэж үзэхэд нөлөөлсөн байдаг.

М.Ганди Дэлхийн I дайны үеэр Их Британий эзэнт гүрнийг дэмжин Антантын талд дайтах нь Энэтхэгт эзэнт гүрний дотор бие даахад нь ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байсан нь угтаа тайван замаар тусгаар тогтнолд хүрэх түүний стратегийн нэг хэсэг байсан.⁵ Гэвч харамсалтай нь метропол Их Британийг дэмжсэн үр дүн гараагүй буюу Энэтхэг дайны дараа тусгаар тогтноход шаардлагатай улс төрийн дэмжлэг хүртэж чадаагүй юм. Энэ нь энэтхэгийн ҮЧХ-ний тэмцэгчдийг цаашид аливаа дайныг идэвхитэйгээр эсэргүүцсэн хийгээд олон улсын байдлын талаар бие даасан байр суурь баримтлахад нөлөөлсөн.

1920-иод оноос М.Ганди нь газар зүйн байршлын төдийгүй соёлын хувьд ойр дөт Азийн ард түмнүүдтэй эрх чөлөөний тэмцлээ нэгтгэснээр колоний эсрэг тэмцлээ үр дүнтэй болгож чадна гэж үзэж байсан нь хожмоо тусгаар тогтносон Азийн улсуудын холбоо үүсгэх санаа болсон юм. Зөвхөн харилцан итгэсэн харилцан хүндэтгэсэн гадаад бодлогыг явуулснаар дэлхийн олон ард түмэн тусгаар тогтнолын төлөө бодитойгоор, тайвнаар тэмцэж чадна гэж тэрээр үзэж байсан нь угтаа Азийн улсуудыг хамарсан Үндэстнүүдийн холбоотой адил төстэй олон улсын байгууллагыг үүсгэх санаа байсан болов уу.

Бүхэлдээ М.Гандигийн гадаад бодлогын стратеги нь тайван замаар энх тайван байдалд хүрэх үзэл санаагаар дүүрэн байв. Тэрээр дайныг, Энэтхэг дайнд оролцохыг эсэргүүцдэг байсан нь дэлхийн II дайны үеэр тод харагддаг бөгөөд “Энэтхэг улс энх тайвны элч байх ёстой” гэж үздэг байсан түүний санааг Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнөөр, үл нэгдэх бодлогоор амьдралд хэрэгжүүлсэн хүн бол Ж.Неру юм.

II. Үл нэгдэх гадаад бодлогын онцлог

Олон улсын харилцааны онолын үүднээс гадаад бодлогын хэв шинж гэдэг нь үндэсний хүчин чадлаа тооцоолсон гадаад бодлогын урт хугацааны зорилгыг томъёолсон ухагдахуун бол тухайн улс олон улсын харилцаанд эзлэх жин нөлөөнөөсөө хамаарч, гадаад бодлогын зорилгоо гүйцэлдүүлэх арга хэрэгслүүрийг онолын тодорхой

үндэслэлтэй сонгохыг гадаад бодлогын стратеги хувилбар хэмээн тодорхойлж болох юм.

Өөрөөр хэлбэл, аливаа улсын гадаад бодлогын хэв шинж нь агуулга байдаг бол гадаад бодлогын хувилбар нь хэлбэр юм. Олон улсын харилцааны түүхэн явцад их гүрний ба жижиг улсын гадаад бодлогын хэв шинжтэй зэрэгцэн, хүчээр далайлгах, төвийг сахих, өөрийгөө тусгаарлах, үл нэгдэх, прагматик гэсэн гадаад бодлогын хэд хэдэн хувилбар төлөвшсөн бөгөөд чухам ямар арга хэрэгслүүрээр үндэсний эрх ашигаар илэрхийлэгдсэн гадаад бодлогын зорилгодоо хүрэхийг эрмэлзэж байгаагаас нь хамаарч дотроо задарч болдог.

“Хүйтэн дайн”-ы ид үед Энэтхэг тэргүүтэй шинээр тусгаар тогтносон улсууд үл нэгдэх гадаад бодлогын хувилбарыг сонгосон нь утгаа хөгжиж байгаа, шинэ залуу улсуудад аль нэг их гүрний дарамт, шахалтаас гадна, үзэл суртлаас ангид өөрсдийн ашиг сонирхлыг, аюулгүй байдлыг хангах таатай боломжийг олгосон билээ.

1954 онд Делид Энэтхэг, Хятад хоёр улс нь хоорондын харилцаандаа энхээр зэрэгцэн орших “панчашила”-ийн

1. Харилцан газар нутгийн бүрэн бүтэн байдал, бүрэн эрхийг хүндэтгэх
2. Үл довтлох
3. Дотоод хэрэгт оролцохгүй байх
4. Адил тэгш ба харилцан ашигтай байх
5. Энхээр зэрэгцэн орших гэсэн үндсэн 5 зарчмыг тунхагласан.

Энэхүү зарчим нь 1955 оны 4 дүгээр сарын Ази, Африкийн орнуудын Бандунгийн бага хурал дээр цаашид дэмжигдэн хөгжсөн нь үл нэгдэх бодлогын үндэс болсон гэж үздэг. Цаашид дээрх зарчмууд Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг үүсгэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

1961 оны 9 дүгээр сарын 1-6-нд Югослав, Энэтхэг, Египет, Индонези, Гана улсуудын санаачлалаар дэлхийн 25 улс чуулж, Эвсэлд Үл Нэгдэх Хөдөлгөөн (ЭҮНХ)-ийг үндэслэсэн. Энэ үеэс “Хүйтэн дайны” үеийн хоёр туйлын алинд ч үл хамаарахыг хүссэн гуравдагч ертөнцийхнийг нэгтгэсэн “үл нэгдэгсэд” гэсэн тодотголтой эвсэл үүссэн юм. Энэхүү хөдөлгөөний гол зорилго нь олон улсын харилцааны тулгамдсан асуудлын нэг “умард-өмнөдийн” асуудлыг шийдвэрлэхэд оршдог.

Үл нэгдэх гадаад бодлогын чиглэлийг дэлхийн II дайны дараа тусгаар тогтносон ихэнх улс баримтласан бөгөөд энэхүү гадаад бодлогын хүрээнд олон улсын харилцаанд энх тайван, аюулгүй байдлын төлөө, тэгш эрхтэй, цэргийн-улс төрийн эвсэл холбооны гадна оролцохыг хөгжиж буй орнууд гол зорилгоо болгодог. Үл нэгдэх бодлогыг үндэслэгчдийн нэг Ж.Неру тусгаар тогтносон Энэтхэг улсад үндэсний ашиг сонирхлоо хамгаалж, энх тайван байдлыг хангахад үл

хамаарах чөлөөт бодлого шаардагдана гэдгийг ойлгож байв. Иймээс Ж.Неру үл нэгдэх замаар энх тайвныг сахин хамгаалах боломжтой гэж үзсэн. Түүний үзэж байснаар үл нэгдэх бодлогын зарчим нь

1. Дайсагнагч эвслүүдтэй хамтрах замаар тэднийг ойртуулах

2. “Намжмал бүс”-ийг үл нэгдэх улсуудаар өргөжүүлэн, олон улсын харилцааг тогтворжуулах явдал байсан юм.⁶

Шинээр тусгаар тогтносон Энэтхэгийн шинэ Засгийн газрын хувьд хөгжлийн өрнөдийг түшсэн загвар нь түрэмгийллийг гарцаагүй үүсгэх шинж чанартай байсан бол Зөвлөлтийн байдал нь Энэтхэгийн үндэсний хөдөлгөөнд харшлах диктатур дарангуйллыг агуулж байсан. Иймээс аль ч улсын хөгжлийн загварыг хуулбарлах бус, харин өөрийн хөгжлийг тодорхойлох ёстойг энэтхэгийн үндэсний чөлөөлөх хөдөлгөөний удирдагчдын нэг зөв ухаарч чадсан байна. Мөн үүнээс гадна үл нэгдэх бодлогыг бүрдүүлэхэд Энэтхэгийн шашин-сэтгэлгээний онцлог, тухайлбал хүч үл хэрэглэх, үл хамтрах үзэл санаа нөлөөлсөнийг мартаж болохгүй юм.

Нөгөөтэйгүүр Энэтхэгийн газар зүйн байршил гадаад бодлогод нь нөлөөлсөн гэж үзэх үндэслэл бий. Энэтхэг нь тухайн үедээ хөгжиж буй орнуудаас бүрдсэн “Өмнөд”-д харъяалагдаж буйгаа сайтар ухаарч, түүнийг тойрон орших Ази, Африкийн шинэ залуу тусгаар тогтносон хийгээд колони, хагас колони улсуудтай хөгжил нь салшгүй холбоотойг мэдэж байв. Тусгаар тогтносон Энэтхэгийн хувьд хараат, хагас хараат улсуудын хүрээлэл дунд оршин тогтнох нь түүний хөгжилд сөргөөр нөлөөлөх магадлалтай байсан. Иймд Энэтхэг өөрийн улсын хүчин чадал, боломжийг тооцоолон үзсэнээр олон улсын тавцанд тодорхой үүрэг гүйцэтгэхээр эрмэлзэх, өөрийн гэсэн тойрон хүрээлэгчид бүхий нэр хүндтэй улс байхыг зорьсон. Энэ нөхцөлд үл нэгдэх бодлогыг бусад улсуудад түгээн тараах шалтгаан бодитоор байсан юм.

Ж.Неру үл нэгдэх гадаад бодлогын үндсийг “Чөлөөт бодлого нь энхээр зэрэгцэн орших, үл нэгдэх зарчимд суурилж, үндэсний чөлөөлөх хөдөлгөөнүүдийг дэмжигч, цэргийн эвсэлд оролцохгүй, их гүрнүүдтэй байгуулах хоёр талын цэргийн хэлэлцээрээс татгалзаж, өөрийн улсын газар нутаг дээр гадны цэргийн баазыг байрлуулахгүй байхад оршино” гэж тодорхойлсон байдаг.⁷

Иймээс үл нэгдэх бодлого нь “тусгаарлах”, “төвийг сахих” бодлогуудаас эрс ялгарсан бөгөөд зөвхөн дайны үед төвийг сахина, Энэтхэгийн гадаад бодлого дайныг гаргуулахгүй, энх тайвныг сахин хамгаалахад чиглэсэн идэвхитэй үйл ажиллагаа явуулахыг шаардсан гэсэн зарчмуудыг өөртөө агуулсан байснаараа өмнөх бодлогуудаас ялгарч байв.

Шинээр тусгаар тогтносон, хөгжиж байгаа орнуудын хувьд үл нэгдэх бодлого нь заавал цэрэг-улс төрийн эвсэл холбоонд нэгдэлгүй,

олон улсын тавцанд идэвхитэй оролцож, улс төрийн тодорхой алхмуудаар эдийн засаг-санхүүгийн тусламж олж авах боломжийг бодитоор нээж өгсөн тул бараг ашигтай бодлогод тооцогдсон гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, үл нэгдэх гадаад бодлогын үйл ажиллагаа нь олон улсын улс төрийн харилцаанд идэвхи санаачлагатай оролцож, ОУБ-уудтай нягт хамтран ажилласнаар нэг зэрэг эдийн засгийн хөгжлийн эх үүсвэрийг олох, олон улсын тавцан дахь нэр хүндээ өсгөх боломжийг хангажээ.

“Панчашила”-ийн зарчим болон Энэтхэгийн ХХ зууны 50-иад оны гадаад бодлогын чиглэл, үйл ажиллагаанаас харахад Ж.Неругийн “үл нэгдэх бодлого” нь олон улсын харилцааны онолын “глобалист” буюу неоидеалист онолд суурилсан номлол болох нь харагдаж байгаа юм.

Гэвч 1962 онд Хятад, Энэтхэг рүү цэрэглэн халдсан нь “үл нэгдэх” бодлогод прагматизмыг тусгах, зорилгоос илүүтэй бодит байдал, аюулгүй байдлын асуудлыг илүү тооцоолох шаардлагатайг нотолсон нь Ж.Неруг өөрийн номлолын хоёр дахь чиглэл буюу улс төрийн реализмд тулгуурласан “үл нэгдэх” бодлогыг боловсруулахад нөлөөлсөн.

Реализмд суурилсан “үл нэгдэх” бодлогыг залгамжлагчид 1960-аад онд их гүрнүүдийн үйл ажиллагааг тайлбарлан буруушаахыг түтгэлзэж, энхийг сахиулагч, зохицуулагчийн үүргийг гүйцэтгэн олон улсын харилцаанд эзлэх нэр хүндээ өсгөхийг зорих болсон. Энэ үед И.Ганди “Үл нэгдэх, энхээр зэрэгцэн орших бодлого нь хөгжиж буй орнуудын тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдлын шилдэг баталгаа. Бид нэг ч цэргийн эвсэлд нэгдэхгүй байна. Бид өөрсдийн эрх ашиг, сонирхлоор шийдвэр гаргаж, аль нэг асуудлыг бие даан шийдвэрлэх эрхтэй болж байна. Энэ нь аль нэг эвсэл, их гүрэн, жижиг улс юу ярьж буйгаас үл хамааран дурын асуудлаар өөрсдөө шийдвэр гаргаж байна гэсэн үг. Энэ бол тусгаар тогтнолыг хамгаалах цорын ганц бодлого гэж үзэж байна”⁸ гэж реалист үл нэгдэгсдийн бодлогыг тодорхойлж байв.

1970-аад онд Энэтхэг болон бусад улсууд “үл нэгдэх” бодлогод зөвхөн улс төрийн төдийгүй, түүнээс илүүтэйгээр эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх боломжийг тусгахыг зорих болсон. Ингэснээр үл нэгдэх бодлого нь бодит нөхцөл байдлыг тусгасан прагматик чанарыг илүүтэй агуулах болжээ гэж үзэж болно.

1980-1990-иад онд “үл нэгдэх” бодлого нь улс төрийн хямрал, зөрчлийг арилгах, даван туулахад болон дэлхийн эдийн засгийн хөгжлийн чухал асуудлаар, тухайлбал баян умард, ядуу өмнөдийн харилцаан дахь тэгш бус байдлыг арилгахад гол анхаарлаа хандуулсан шинжтэй байв. Дээр дурдсанчлан үл нэгдэх гадаад бодлого нь глобалист ба реалист гэсэн хоёр стратеги хувилбараар илэрч болно.

Энэтхэгийн гадаад бодлогын түүхээс харахад “үл нэгдэх” бодлого нь сонгодог утгаараа улс төрийн идеалист онолд суурилсан бөгөөд

энэ утгаараа уг номлолыг дэмжигчид ч дэлхийн хамтын нийгэмлэгийн дийлэнх олонхи байдаг.

Нөгөөтэйгүүр өөрийн улсын үндэсний ашиг сонирхлоо хамгаалах, илэрхийлэх хамгийн ашигтай хувилбар нь уян хатан бөгөөд өөрийн байр суурийг илэрхийлсэн идэвхитэй гадаад үйл ажиллагаа явуулах боломж олгогч үл нэгдэх гадаад бодлого мөн гэж үзэж болно.

Энэ тохиолдолд “үл нэгдэх” бодлого нь “Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн”-ий хүрээнд өөрийн үндэсний ашиг сонирхлоо хамгаалах, өөрийн байр суурийг олон улсын тавцанд хамтын хүчээр илэрхийлж, баттай болгох, хамгийн гол нь өөрийн гадаад сонирхлоо гүйцэлдүүлэх боломж олгодог давуу талтай юм.

Олон улсын харилцааны онолын хүрээнд ихэд алдаршсан Мортон Капланы загварчлалын онолын тусламжтай “хүйтэн дайн”-ы үеийн олон улсын харилцааны үйлчилж байсан системийг бүтцийг тодорхойлбол энэ нь уян хоёр туйлт систем⁹ бөгөөд өөрөөр хэлбэл, үл нэгдэгсэд хэмээх өөрийн эрх ашгийн үүднээс төвийг сахигчид байсан тул “Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн” зохицуулагчийн үүрэг гүйцэтгэж ирсэн гэж үзэж болно. Тэд аль аль туйлд нь нөлөөлөх байдлаар хямралыг зохицуулах, хамтын хүчээр дипломат аргаар улс төрийн шахалт үзүүлэх зэргээр системийн бүтцийн тогтвортой байдлыг хадгалахад чухал оролцогчид байсан.

Үл нэгдэх бодлогыг баримтлагчдын хувьд гадаад бодлогын гол зарчим нь энхээр зэрэгцэн орших, өөрийн аюулгүй байдлыг хангахын тулд дэлхий дээр энх тайван байдлыг сахин хамгаалж, зэвсэглэлийг хорогдуулах, олон улсын зөрчил хямралыг энхээр зохицуулах, эдийн засгийн хөгжлийн таатай нөхцлийг олж авахад тулгуурладаг.

“Хүйтэн дайны” үед хоёр эвслийн дунд “үл нэгдэх” байр сууринаас хандаж, хамгийн ашигтай, үр дүнтэй бодлого явуулж байсан хэдий ч, 1990-ээд оноос олон улсын харилцаан дахь улс төрийн уур амьсгал дулаарч, нөгөөгүүр интеграцлалын нөлөөгөөр эдийн засгийн харилцаа илүү таатай болж хөгжиж эхэлснээр “үл нэгдэх” бодлого үр дүнгүй болж байна гэсэн хэт нэг талыг барьсан шийдлийг яаравчлан гаргах нь зохимжгүй юм.

Зүй нь үл нэгдэх бодлого олон улсын харилцааны дийлэнхи олонхи болж байдаг хөгжиж байгаа, буурай хөгжилтэй орнуудад хамтын хүчээр ашиг сонирхлоо илэрхийлж, хамтын хүчээр ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх таатай боломжийг олгосон давуу чанараа хадгалсаар байгаа юм. Хэдийгээр үзэл суртлын дайн дуусч, улс төрийн зөрчилдөөнт байдал үл нэгдэгсдийн хувьд багассан хэдий ч, тэдний хувьд гол тулгамдсан асуудал болох хөгжлийн ялгаат байдал, “өрнө-дорны” тэгш бус харилцааг олон улсын харилцааны олонхи болж байдаг жижиг

улсуудын хувьд ашигтайгаар шийдэх, тэгш байдлыг үүсгэх зэрэг эдийн засгийн, хөгжлийн асуудлууд тулгамдсан чанараа хадгалсаар байгаа тул үл нэгдэх бодлого идэвхитэй оршсоор байх болно.

Ийм ч учраас Энэтхэг улс нь үл нэгдэх гадаад бодлогоосоо татгалзаагүй бөгөөд өнөөдөр ч тус улсын гадаад бодлогын үйл ажиллагаа бүхэлдээ үл нэгдэх зарчмын доор өөрийн улсын эрх ашгийг хамгаалах прагматизмаар дүүрэн байна. Үүний нэг тод илрэл нь олон улсын харилцаанд олон туйлт дэг журам үүсгэхийг дэмжиж байгаа, Хятад, Пакистан, АНУ-тай харилцаагаа сайжруулж байгаа явдал мөн.¹⁰

Монгол Улс 1989 онд Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнд гишүүнчилсний хувьд “үл нэгдэх” бодлогыг өөрийн ашиг сонирхлын үүднээс зөв чиглэлд, зөв нөхцөлд баримталсаар ирлээ. Ялангуяа, хөгжиж буй манай улсын хувьд олон улсын тавцанд дуу хоолойгоо сонсгох боломжийг үл нэгдэх бодлого олгохоос гадна, үндэсний аюулгүй байдлын үүднээс ядаж хоёр хөрштэйгээ дээрх бодлогын хүрээнд харилцах нь ашигтай болохыг сүүлийн жилүүдэд явуулж байгаа манай улсын гадаад бодлого нотолж байна. Энэ талаар Г.Төмөрчулуун “үл нэгдэх хөдөлгөөн нь гурван талын сонирхлыг давхцуулж нэгтгэх гол арга хэрэгслүүр болж чадах юм”¹¹ гэж дүгнэсэн байдаг нь орчин цагт ч үнэ цэнээ алдаагүй дүгнэлт гэж үзэж байна.

Дэлхийн хөгжлийн зүй тогтол ч үнэндээ глобалистуудын талд буй тул энэхүү номлолыг үгүйсгэж болохгүй бөгөөд нөгөөтэйгүүр “үл нэгдэх” бодлого өөртөө төвийг сахих байр суурийг давхар агуулж байдгийг санууштай.¹²

Х.Киссенжер үл нэгдэх хөдөлгөөнийхнийг дүгнэхдээ “тэд “Хүйтэн дайн”-ы үед өөрсдийн төвийг сахих байр суурийг дотоод хэрэгт оролцохгүй явдал гэж үзээгүй бөгөөд тэд “хоёр эвслийн” дотоод хэрэгт оролцох дуртай байж, олон улсын харилцааны хамгийн идэвхитэй, заримдаа шуугиантай оролцогчид байсан. Иймдээ ч олон улсын хурцадмал байдлаас өөрсөлдөө ашиг олохыг эрмэлздэг байсан”¹³ гэжээ.

Манай улс үл нэгдэх бодлогыг баримталснаар уян хатан, прагматик шинж чанарыг өөрийн гадаад бодлогын урт хугацааны стратеги болон үйл ажиллагаандаа тусгаж ирсэн.¹⁴ Үр дүнд нь хоёр хөрштэйгээ болон дэлхийн хүчирхэг их гүрэн АНУ-тай нэг зэрэг таатай харилцах боломжийг өөртөө олгож чадаад байна.

Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлалаас үзсэн ч хөгжиж буй жижиг улсын хувьд олон улсын тавцанд өөрийн үгийг сонсгох, зорилгыг хэрэгжүүлэх, хамгийн гол нь өөрийн аюулгүй байдлыг тайван замаар хангах гол гарц нь “үл нэгдэх” бодлого мөн юм.¹⁵

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Ж.Энхбаяр. М.К.Ганди.Хүчирхийллийн эсрэг тэмцэгч. // "Олон улс судлал" №3 2006.120-124-р тал
2. Горошко.Г.Б. История национально-освободительного движения Индии.Внешнеполитические воззрения и позиция по международным вопросам. М, 1991. с.1
3. The Encyclopdedia of the Indian National Congress. Vol.VIII: 1921-1924. India at the Cross roads, ed.by A.M.Laidi and Dr.S.G.Laidi.Delhi,1980.pp.389-390
4. Madan Gopal. India as a world power. Aspects of foreign policy. New Delhi.1948
5. Горошко.Г.Б. Указ.соч.с.38
6. Jawaharlal Nehru. India Today and Tomorrow.//”Readings from India” ed.G.N.S.Raghavan. New Delhi,1996.pp.126-135
7. Е.С.Журавлёва и В.П.Кочетов “Внешняя политика Индии 1964-1989”, Москва.1991,стр.5
8. Мөн тэнд, стр 12
9. Цыганков.П.А. Теория международных отношений. М, 2005. с.183
10. Ф.Юрлов. От колониальной зависимости к растущей великой державе. //”Ази и Африка сегодня” №9 2007.с.4-12
11. Тумурчулуун.Г. Политика МНР в отношении Движении неприсоединения (1961-1990). Диссертация на соискания ученой степени к.н.н. 1990г., Дип. Академия МИД СССР. 1990, с.29
12. М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр, Олон улсын эрх зүй, УБ. 1999, 268-р тал
13. Генри Киссенджер.Дипломатия. М, 1997, с.508
14. Г.Төмөрчулуун. Прагматизм: 90-ээд оны Монголын гадаад бодлогын үндэс. //”1990-иэд оны олон улсын харилцааны чиг хандлага, Монгол ба их гүрнүүд” УБ.121-131-р тал
15. Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. 1994 он